

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

№ТУЗТ 01/2022

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2021 оны жилийн эцсийн “Санхүүгийн тайлан” болон “Үйл ажиллагааны тайлан”-д дүгнэлт өгөх, Ноогдол ашиг хуваарилахгүй байх, Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг олгох, Сонирхолын зөрчилтэй хэлцэл баталгаажуулах тухай

Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2, 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.11, 76.1.12, 76.1.17, 76.1.18, 76.2 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.4.4, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Эрдэнэс сольюшинс” ХК (“Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.4, 10 дугаар зүйлийн 10.2.5, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, “Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэл тарааж олгох журам”-ын 1-р зүйлийн 1.1.2, 1.1.3, 1.1.4, 1.1.5 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК-ийн хийсэн аудитын тайланг зөвшөөрч, дүгнэн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр тогтоосугай.
2. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг зөвшөөрч, дүгнэн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр тогтоосугай.
3. Компани 2021 оны цэвэр ашигаас ноогдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
4. Компанийн тухай хууль болон “Эйс Ассошиэйтс ББСБ” ХХК-ийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүргийг “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нэрийн өмнөөс төлөөлж “Эйс Ассошиэйтс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд эдлэх, нэмж хувьцаа гаргах, нэмж гаргах энгийн хувьцааны үнэ тогтоох, компани төлөөлж гэрээ хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
5. Компанийн “Субашид тек” ХХК-тай 2021 оны 01-р сарын 01-ний өдөр байгуулсан сонирхолын зөрчилтэй “Зээлийн гэрээ”, өгсөн зээлүүдийг зөвшөөрч баталгаажуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Г.ЗОЛБОО/